



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 7 сарын 01 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

XXV ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXV хурал 2020 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 11:00 цагт Төрийн ордны Шадар сайдын өрөөнд 80 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Ө.Энхтүвшин даргалав.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах эсэх талаар;

*ОБЕГ-ын Тэргүүн дэд дарга, бригадын генерал
Г.Ариунбуян*

2. Элсэлтийн ерөнхий шалгалт зохион байгуулах талаар;

*БСШУС-ын яамны Төрийн нарийн бичгийн дарга
Л.Цэдэвсүрэн*

3. ОХУ болон БНХАУ-аас нутаг буцах хүсэлтэй иргэдийг татан авах талаар;

*Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал
Б.Мөнхтүшиг*

4. 7 дугаар сарын сүүлийн хагаст үйлдэх захиалгат нислэгийн талаар;

*Гадаад харилцааны яамны Консулын газрын захирал
Б.Мөнхтүшиг*

5. Бизнес эрхлэлтийг дэмжих зорилгоор халдвар хамгааллын дэглэмийг сахиж олон нийтийн үйлчилгээг үе шаттай эхлүүлэх талаар;

*Нийслэлийн Засаг даргын орлогч
Ж.Батбаясгалан*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

А. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 147 дугаар тогтоолын 1 дүгээр хэсэгт заасан гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг 7 дугаар сарын 15-ны өдрийг дуустал хугацаанд сунгах, энэ асуудлаар хилийн боомтод авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр тогтов.

Нэг. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд Ё.Баатарбилэг,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

1.1. Их, дээд сургууль, коллежийн бакалаврын ангид 2020-2021 оны хичээлийн жилд элсэн суралцах хүсэлтэй иргэдээс авах элсэлтийн ерөнхий шалгалтыг Улсын хэмжээнд 2020 оны 7 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд холбогдох түр журмын дагуу зохион байгуулах;

Хоёр. Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл,
Гадаад харилцааны сайд Д.Цогтбаатар,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,
Цагдаагийн ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал С.Баатаржав,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү,
Сэлэнгэ аймгийн Засаг дарга,
Аймгийн онцгой комиссын дарга Ш.Оргил,
Дорноговь аймгийн Засаг дарга,
Аймгийн онцгой комиссын дарга Т.Энхтүвшин нарт:

2.1. Тусгаарлах байрны хүрэлцээ боломж, нөхцөлийг харгалзан ОХУ-аас нутаг буцах хүсэлт гаргасан Монгол Улсын иргэдийг хилийн Алтанбулаг боомтоор, БНХАУ-аас нутаг буцах хүсэлт гаргасан иргэдийг хилийн Замын-Үүд боомтоор тус тус татан авч, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;


Гурав. Батлан хамгаалхын сайд,
Улсын онцгой комиссын орлогч дарга Н.Энхболд,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга,
Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Т.Бадрал,
Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал Д.Ганзориг нарт:

3.1. Батлан хамгаалах гадаад хамтын ажиллагааны хүрээнд төлөвлөгдсөн олон улсын болон хоёр шатны сургалт, дадлага цэргийн мэргэжлийн олон улсын уралдааныг зохион байгуулахгүй байх, түүнчлэн гадаадын улс орнуудад зохион байгуулагдах сургалт, дадлага, уралдаан тэмцээнд цэргийн алба хаагчдыг 2020 оны 8 дугаар сарын 30-ны өдрийг дуустал хугацаанд оролцуулахгүй байх;

Дөрөв. Аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт:

4.1. Улс орны эдийн засаг, хувийн хэвшлийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих зорилгоор жагсаал цуглаан, нийтийг хамарсан спорт үйл ажиллагаа, РС тоглоомын газар, диско болон бүжгийн баарнаас бусад бүх төрлийн хүүхдийн тоглоомын газар, баар, биллиард, шашин, соёл урлаг, үзвэр үйлчилгээний газрын үйл ажиллагааг халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдүүлэн үе шаттайгаар нээхийг зөвшөөрөх;

ДАРГА,
ШАДАР САЙД



Ө.ЭНХТҮВШИН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ

Д.САНЖАА